

ИСЛАМЫН АНАГААХ УХААНЫ ЭРТНИЙ НЭГЭН НОМЫН СУДАЛГАА

Очирхүү Самбуу¹, Эрдэнэ Ариунаа², Дашжамц Шагдарсүрэн²,
Баттогтох Гэрэлмаа², Баасанжав Халиунаа², Шарав Болд^{1,2*}

Уламжлалт Анагаах Ухааны Тэнхим

¹Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль

²"Ач" Анагаах Ухааны Их Сургууль

*Цахим хаяг: shrvbold@gmail.com

A STUDY OF AN ANCIENT BOOK OF ISLAMIC MEDICINE

Sambu Ochirkhuu¹, Ariunaa Erdene², Shagdarsuren Dashjamts²,
Gerelmaa Battogtokh², Khaliunaa Baasanjav², Bold Sharav^{1,2*}

Department of Traditional Medicine

¹Mongolian University of Pharmaceutical Sciences

²"Ach" Medical University

*Email: shrvbold@gmail.com

Abstract

Introduction: Among the ancient medical books, manuscripts written in clear script, with unique vocabulary and treatment methods, have been found. The vocabulary in this work is very ancient, and the treatment methods are systematic, with few mentions of theoretical concepts. Most of the unfamiliar words were written in the pronunciation of the ancient Oirat Torghut and Dorbet. Some of these words were of Uyghur and Sartuul (Khui Khui) origin. Therefore, we worked to determine when and by whom this book was written, what its content was, and which direction of medicine it belongs to.

Objectives: To study an ancient book written in clear script, containing Islamic medical knowledge, found in Mongolia.

Results: "The Healing Charm of Blue Ram" (Khцkh khutsyn uvdis orshivai) records that Genghis Khan ordered Chagatai Khan to send him medical books from his land. He may have been in poor health shortly after the founding of the Chagatai state in 1225. Thus, he ordered Chagatai to send him books containing medical methods. It is reasonable to assume that the books were sent in 1226. At that time, the Chagatai state was highly developed, consisting of many ethnic groups, including Khorezm, Sartuul, and Uyghurs, who practiced Islam. In particular, the medical field was well advanced, resulting in many excellent doctors and medical books. We tried to list and explain a total of 15 words from "The Healing Charm of Blue Ram," with many more to explore in the future. In general, it is hypothesized that many vocabulary related to medicine have spread to the Mongolian vocabulary through Arabic, Turkic, Uyghur, and Sartuul among the Western Mongolians. Conclusion: The ancient book "The Healing Charm of Blue Ram" found in Mongolia, written in clear Mongolian script, contains Islamic medical knowledge, as well as traditional Mongolian medicine methods, as is clear from the explanations of some vocabulary related to medicine. In the future, it is important to further clarify how Mongolian medicine and Islamic medical knowledge influenced each other and the contribution of Mongol khans to the development of the Ilkhanate and the Chagatai state in the study of the history of Mongolian medicine.

Keyword: Islamic medicine, healing, medical books, medical knowledge

Үндэслэл

Монгол Улсад уламжлалт анагаах ухаан салбар бүрээр сэргээгдэн хөгжих эхлэл 1990 онд тавигдсан. Энэ үеэс эхлэн бид Монголын уламжлалт анагаах ухаан, Хятадын уламжлалт анагаах ухаан, Энэтхэгийн Аюурведийн анагаах ухаан, Төвөдийн анагаах ухаан, эртний Европын анагаах ухааны монгол бичиг, тод

монгол үсэг, хятад, төвөд, манж, орос хэлээр бичсэн, эсвэл эдгээр хэлнээс орчуулсан эртний номуудыг олж цуглуулах, судлах ажлыг эхлүүлсэн. Гэтэл анагаах ухааны эртний эдгээр номуудын дотор үг хэллэг, эмчилгээний арга нь өвөрмөц тод монгол бичгээр бичсэн гар бичмэл номууд олдсон. Энэ номыг сайтар уншиж үзвэл үгүүд нь их эртнийх, эмчилгээний аргууд нь

цэгцтэй, онолын ойлголтыг бага бичсэн ном байв. Үл таних ихэнх үгнүүд нь эртний Ойрадын торгууд, дөрвөд түмний дуудлагаар бичсэн. Эдгээр үгийн зарим нь Уйгар, Сартуул, Хотон (Хуй Хуй) гаралтай байв. Тиймээс бид энэ номыг хэдий үед хэн бичсэн, ямар агуулгатай, анагаах ухааны аль чиглэлд хамаарах эсэхийг тогтоохоор ажиллав.

Зорилго

Монгол нутгаас олдсон Исламын анагаах ухааны мэдлэгийг багтаасан, тод монгол үсгээр бичсэн эртний нэгэн номын судалгаа

Судалгааны эх хэрэглэгдэхүүн

“Хөх хуцын увдис оршивай”. Тод монгол үсгээр бичсэн гар бичмэл ном.

Судалгааны аргууд

- Эх бичиг судлалын арга

Судалгаанд ашигласан хэрэглэгдэхүүнээ ажлынхаа зорилго, зорилтууддаа нийцүүлэн зохиогчийнх нь төрсөн болон амьдарч байсан цаг хугацаагаар хамгийн эрт үеэс нь эхлэн эрэмбэлэн судалж, улмаар гол агуулга, сэтгэлгээний хувьд шинэлэг санааг бусад

эх зохиолуудтай харьцуулан, шүүн тунгааж үзэв. Энэ аргаар “Хөх хуцын увдис оршивай”. Тод монгол үсгээр бичсэн гар бичмэл ном нэр, газар орон, агуулга, эх хэрэглэгдэхүүн, галиг, тайлбар, харьцуулалт зэргийг нэгэн дор хамтатган судална.


- Харьцуулалтын арга

“Хөх хуцын увдис оршивай”. Тод монгол үсгээр бичсэн гар бичмэл номонд байгаа араб, перс, түрэг, уйгар гаралтай нэрийг хэл шинжлэлийн болон уламжлалт анагаах ухааны нэр томъёог тайлбар бичгүүдээс тодруулж, хооронд нь харьцуулан гарал үүсэл, ялгаатай, төсөөтэй талуудыг тогтооно.

Судалгааны ажлын үр дүн

1. Номын хэмжээ, эхлэл болон төгсгөлийн хэсэг

“Хөх хуцын увдис оршивай”. Тод монгол үсгээр бичсэн гар бичмэл ном. Болгомол цаасан дээр хар бэхээр бичсэн 41 хуудастай, 15x11 см хэмжээтэй, тод монгол үсгийн ном. Гарчиг бүхий эхний хуудасны дараагийн хуудаснаас нэг гэж дугаарлан ийнхүү бичжээ.



1v. Долоон барсын мах идвэл цэцэг гарахгүй. Барсын манлайн¹ арьс гуруулж² идвэл барс халах үгүй. Барсын мах, цагаан хулдын³ сөд баруун живэр⁴ галзууд эм. Хунгийн өд чихдээ дүрвэл⁵ тасын өд болох. Дунг айрагт дүрвэл

дэвтээх. Үмхий⁶ усанд цэрд хийвэл арилах. Цахилгааны архиас үл давах. Зааны соёод өвс норгож хөндлөн тавибал батгана үл идэх. Маажмын тос⁷ заг хоёрыг зуурч түрхвэл сахал үс цайсныг хар бол(г)ох. Гүргэм үүртэй зуур ...¹.

Хамгийн сүүлийн 41r хуудасны бичвэрийг тод монгол үсгээс орчуулбал:

¹ Манлай - магнай

² Гууруулах - гуужуулах


³ Хулд – шувууны нэгэн зүйл

⁴ Живэр – жигүүр

⁵ Дүрэх – хийх

⁶ Үмхий – өмхий

⁷ Маажмын тос – маажин тос (маажийн үрээс шахаж авсан анхилам үнэр, амттай хүнсний тос)



41 г. өвчин, ям өвчинд бугын цус уулга. Хон хэрээний мах үед суухад эм. Загасны мах, шингэн хоёр хольж идвэл бэтгийг эдгээюү. Галд түлсэнд нохойн цус түрх. Булархай хавдарт эм хүний толгойн яс үйлж тэлүүл. Хамар өөд хижиг урвасанд үхэр бөөлжиргөний иш буцалгаж анжис хоёр хольж өг. Үнэгний мах уулийн мах идвэл уушгины өвчин эдгэрэх. Алт мөнгө хоёр чулуу хольж идвэл шар ус арилах. Чацаргана бас усны цэцгийн сар хамтгаас зай нийлүүлж өг. Цусаар суухад сайн... гэж бичжээ².

2. Номыг бичсэн цаг хугацаа, эмчилгээний аргууд

Номын 38г хуудсанд Чингис хаан Цагаадай хаанд өөрийн нутгаас анагаах ухааны ном байвал өгч явуулахыг зарлиг болгосон тухай тэмдэглэсэн байна³. Тухайн үед Цагаадай хаан (1183-1242) Уйгараас Амударьяа мөрөн хүртэлх нутгийг захиран сууж байв. Тэрбээр 1225 онд Цагаадайн улсыг байгуулаад удаагүй байхад магадгүй Чингис хааны бие чилээрхсэн тул эмчилгээний арга бүхий ном өгч явуулахыг Цагаадайд зарлиг болгосон байх⁴. Ном илгээсэн хугацааг 1226 онд гэж таамаглах үндэстэй юм. Тухайн үед Цагаадайн улс нь Хорезм буюу Сартуул, Уйгарын Исламын шашинтай, өндөр хөгжилтэй олон үндэстнээс бүрдсэн орон байв. Ялангуяа анагаах ухаан сайн хөгжсөн үүнийгээ дагаад олон сайн эмч, анагаах ухааны ном бүтээлтэй байжээ. Энэ талаар дуулж мэдсэн Чингис хаан 1227

онд нас барахаасаа өмнө 1226 онд зарлиг буулгасан энэхүү номыг авчруулсан байна.

Энэхүү номонд байгаа эмчилгээний аргыг өвчний нэрээр нь нэгтгэн ангилбал:

- Арьсны өвчин анагаах арга - 5
- Шүдний өвчин анагаах арга - 2
- Цус тогтоох арга - 6
- Чихний өвчин анагаах арга - 3
- Нүдний өвчин анагаах арга - 5
- Хоол боловсруулах эрхтний өвчин анагаах арга - 9
- Шээс, бэлгэ эрхтэний өвчин анагаах арга - 6
- Сэтгэл мэдрэлийн өвчин анагаах арга - 4
- Халдварт өвчин анагаах арга - 6
- Гэмтэл, мэс заслын өвчнийг анагаах арга - 23
- Мал амьтны өвчин анагаах арга - 9 тус тус байна⁵.

Энэ ном Монголд уламжлагдснаар Исламын анагаах ухааны мэдлэг Уйгар, Сартуулын анагаах ухаанаар дамжин ирж үндэстэн хооронд анагаах ухааны мэдлэг солилцох үйл ажиллагааны эхлэл болсны зэрэгцээ анагаах ухааны талаарх төрийн анхны шийдвэрийн нэг болж байжээ.

“Хөх хуцын увдис оршивай” номонд гэмтэл, мэс заслын өвчийг анагаах арга хамгийн их бичигдсэн нь Монголын анагаах ухааны мэс заслын салбарын хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн байна⁶. Ялангуяа тархины яс хагарсанд ясыг нь цоолоод тархинаас авч дундуурлаад хальсыг нь эвлүүлээд төөнө

гэсэн арга нь Монгол анагаах ухааны тархины мэс заслын нэн эрт үеийн арга болох нь харагдаж байна.

3. Номын Исламын анагаах ухаантай холбогдох баримтууд

“Хөх хуцын увдис оршивай” номын доторх зарим үг, эмийн ургамал, улс орны нэрүүд нь Уйгар, Түрэг, Араб, Сартуул гаралтай үгүүд байна. Ялангуяа Хотон гэсэн нэр олон удаа гарч байна. Хотончуудыг хятадаар Хуй гэж дууддаг. Ер нь бол Уйгар гаралтай Исламын шашинт хүмүүс юм. Хотончууд 1690 оны орчим Монголд суурьшин хүнсний ногоо тарьж амьдарч эхэлсэн гэж үздэг. Монгол Улсад 2010 оны хүн амын тооллогоор 11304 Исламын шашинтай Хотон ястан амьдарч байна⁷.

Бид судалгааны явцад дараах түрэг, араб, уйгар гаралтай байж болох үгийг түүвэрлэн тайлбар хийв. Эртний номын доторх үг хэллэг нэн эртнийх, уншиж гарахгүй үгнүүд олон байсныг дурдаад зарим үгийн тайлбарыг онож чадаагүй байж болзошгүй. Үүнд:

1. *Авдал* – (Abdal) - Ginseng
2. *Авла хожийн эмнэлэг* – (Avla hoji emneleg (Avla hastane) -Avla hoji Hospital
3. *Алих* – (alikh) - el ayasi - palm
4. *Архи* – (arajhi. Tu. from Ar.) - distilled liquor
5. *Гашиг* – (qashiq. Tu.) – spoon
6. *Лошодор* – (loşodor) - a type of stone
7. *Маажм тос* – (mäskä. Tu.) - refined liquid butter
8. *Махэ* (Хотон) – (mahe. Uyghur) - Ginseng
9. *Сулайман* – (Sulaiman) - Derived from the Arabic word salaam, meaning peace, Sulaiman epitomizes a name rich in peaceful connotations.
10. *Улир* – (ulir) - snow cock
11. *Умш* – (umsh) - pasta
12. *Халбүүр* (hulba. Ar.) - fenugreek
13. *Хотон* – (Hoton) - Uyghur
14. *Хотон яр өвчин* – (Hoton yar üvchin) - Uyghur ulcer
15. *Хурмаш* – (hurmarsh) - left shreds
16. *Шөл* – (shilön. Tu.) - soup
17. *Элээдшиг* – (eleedshig) - grown-up гэх мэт. Эдгээр үгийг бид “Хөх хуцын увдис оршивай”

номноос магадлан жагсааж тайлбарлах оролдлого хийлээ. Цаашид өөр олон дундын үгүүд байна. Ер нь Монгол хэлний үгсийн санд Араб, Түрэг, Уйгар, Сартуулаар дамжин баруун Монголчуудын дунд анагаах ухаантай холбоотой цөөнгүй үг тархжээ гэсэн таамаг дэвшүүлж байна.

Хэлцэмж

Аравдугаар зуунд Араб-Персийн анагаах ухаан Исламын шашинтай хамт орж ирсэн. Үүгээр Грек-Ром, Араб-Перс, Уйгурын анагаах ухааны мэдлэгүүд анагаах ухааны цогц байдлаар нэг систем болсон. Энэхүү системийн тулгуур үндсийг Уйгур, Хотонгууд ихээхэн хэмжээгээр хадгалагдан үлджээ. Ялангуяа Уйгурын анагаах ухааны хоёр мянган жилийн уламжлал нь Монгол үндэстэнд дэлгэрэх үүдийг нээж⁸, монголчуудын дунд домын судар нэрээр алдаршсан анагаах ухааны хялбаршуулсан мэдлэгүүд монгол бичиг, тод монгол бичгээр олонтоо бичигдэн уламжлагдсан. Монголд дэлгэрсэн домын судрууд тухайлбал “Хөх хуцын увдис оршивай”, “Урианхай ардын домын судар”, “Хөх хуцын домнолгон оршив” бэсрэг номуудад монголчуудын домын аргаас гадна Исламын анагаах ухааны аргууд янз бүрийн хэлбэрээр бичигдсэн байна. Эдгээр аргууд 1070 онд Юсуф Хас-Хажиб (Yusuf Has-Hajib)-ын бичсэн “Kutadgu-bilig-Хутагду билиг” (Адисласан мэдлэг) номонд тэмдэглэгдсэн гэж үзэх үндэстэй байна⁹. Энэ бүтээл Уйгурын утга зохиолын хамгийн эртний ололтуудын нэг болох бөгөөд «Хэрхэн ухаалаг, аз жаргалтай амьдрах вэ?» хэмээх сургаалын шүлэг юм. Исламын анагаах ухааны зарим мэдлэг түгэхэд Цагаадай хэл чухал үүрэг гүйцэтгэсэн. Цагаадайн улсыг үүсгэн байгуулаад, байгуулсан улсдаа Цагаадай хаан шинээр бичгийн хэлийг бий болгон хөгжүүлжээ. Цагаадайн хэлийг Төв Азийн Түрэг улсууд 13-р зуунаас 19-р зуун хүртэл бичгийн хэл, улмаар дипломат хэл болгон ашиглаж байжээ.

Арван нэгдүгээр зуунаас Уйгурчуудын хэрэглэж эхэлсэн араб бичгийн (Цагатай) өөрчлөгдсөн хувилбараар бичигдсэн байв.

Гэвч хуучин уйгур бичиг тэр дороо устаж алга болоогүй бөгөөд энэ бичгээр бичсэн олон бүтээл өнөөг хүртэл хадгалагдан үлджээ. Юсуф Хас-Хажиб (Yusuf Has-Hajib)-ын бичсэн “Kutadgu-bilig” ном Уйгар бичгийн хэлээр бус харин Цагаадай хэлээр бичгдсэн гэж үздэг. Цагаадай хэлээр Исламын анагаах ухааны олон арван ном бичигджээ.

Дүгнэлт

Монгол нутгаас олдсон Исламын анагаах ухааны мэдлэгийг багтаасан, тод монгол үсгээр бичсэн “Хөх хуцын увдис оршивай” эртний ном нь монголчуудын домын аргаас гадна Исламын анагаах ухааны аргуудыг багтаан бичсэн нь анагаах ухаантай холбоотой зарим үгийн тайлбараас тодорхой байна. Цаашид Монголын анагаах ухааны түүхийн судалгаанд Монголын анагаах ухаан болон Исламын анагаах ухааны мэдлэгүүд хэрхэн харилцан нөлөөлж байсан, Ил хаант улс, Цагаадай улсын хөгжилд Монгол хаадуудын оруулсан хувь нэмрийг тодруулах асуудал чухлаар тавигдаж байна.

Ном зүй

1. “Хөх хуцын увдис оршивай”. Тод монгол үсгээр бичсэн гар бичмэл ном. х.1
2. “Хөх хуцын увдис оршивай”. Тод монгол үсгээр бичсэн гар бичмэл ном. х.41
3. “Хөх хуцын увдис оршивай”. Тод монгол үсгээр бичсэн гар бичмэл ном. х.38
4. Б.Пүрэвсүрэн, Болд Ш. Нүүдэлчдийн анагаах ухааны урлаг, дом заслын түүх. Боть 21, УБ, х.80
5. Б.Пүрэвсүрэн, Болд Ш. Нүүдэлчдийн анагаах ухааны урлаг, дом заслын түүх. Боть 21, УБ, х.81
6. “Хөх хуцын увдис оршивай”. Тод монгол үсгээр бичсэн гар бичмэл ном.
7. Буянбадрах Ч. Монгол орны лавлах. УБ, Мөнхийн үсэг, 2012
8. Amir Abdukadir, Denis Dubrovin, NurmahamatAmat, Wenxian Liu, Ayshamgul Hasim, Anwar Aikemu, Batur Mamtimin, Halmurat Upur. The origins of Uyghur medicine: Debates and perspectives.

Journal of Traditional Chinese Medical Sciences. Volume 2, Issue 4, October 2015, p.217-226

9. Amir Abdukadir, Denis Dubrovin, NurmahamatAmat, Wenxian Liu, Ayshamgul Hasim, Anwar Aikemu, Batur Mamtimin, Halmurat Upur. The origins of Uyghur medicine: Debates and perspectives. Journal of Traditional Chinese Medical Sciences. Volume 2, Issue 4, October 2015, p.217-226